



Стратегийн болон боломжит стратегийн ордуудыг матрицын шинжилгээний аргаар үнэлсэн үнэлгээний дүн

Э.Эрдэнэчимэг¹, Н.Мөнхбилэг^{2*}, З.Ганбаатар², Б.Асралт³

¹Азийн дэд бүтцийн судалгааны хүрээлэн,
²МУИС, ШУС, Геологи, геофизикийн тэнхим
³ШУТИС, МТС, Тээвэр, логистикийн тэнхим

ABSTRACT

This study was aimed for "The development of proposals for improving the current legal and regulatory framework of the mineral resource sector, to determine the current and future trends in commodity markets, to propose which mines to prioritize on development on the basis of the current state of development of the industry".

The study goals are:

1. A general overview of the Mongolian socio-economic status and especially the role of the mining sector within the economy;
2. An overall mineral resource commodity study on the current global, regional and neighbouring country markets and their trends;
3. A study for the reserve, extraction, production and beneficiation of mineral resource commodities based on strategic and potential strategic deposits and their mineral classifications;
4. To identify the top priority mines and deposits from the strategic and potential strategic deposits by the SWOT matrix analysis methodology;

To study the current Mongolian legal and regulatory framework on the mineral resource sector and to ultimately provide feedback and proposal to further the improvement and development of the mineral resource sector.

Key words: Evaluation of mineral resources, mining and strategic deposits and matrix analysis method

* Corresponding author. Tel.: +976-99025099

E-mail address: munkhbileg@num.edu.mn

Оршил

Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуульд ашигт малтмалын ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түгээмэл тархацтай ашигт малтмалын орд, ердийн ашигт малтмалын орд гэж ангилдаг. Тус хуулийн 4.1.12-т "Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд гэж үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг хэлнэ" гэж заасан байна. 2007 оны 2-р сарын 6-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 27-р тогтоолоор 15 ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулж, нөөц нь илэрсэн 39 ордыг нөөцийг нарийвчлан тогтоож стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах эсэх тухай саналыг УИХ-д өргөн барихыг даалгасан байна. Түүнчлэн Хөшөөт, Цайдамнуурын нүүрс,

Гацууртын алт, Халзанбүргэдэй, Лугийн гол, Мушгна худаг, Хотгорын газрын ховор элементийн ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ангилалд хамааруулах тухай санал гарган "27-р тогтоолын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн юм. Ашигт малтмалын тухай хуульд барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой, элбэг тархалт бүхий хурдас, чулуулгийн хуримтлалыг түгээмэл тархацтай ашигт малтмалын ордод хамааруулна; бусад төрлийн ашигт малтмалын хуримтлалыг ердийн ашигт малтмалын ордод хамааруулна гэж заасан байна.

Судалгааны өгөгдөл

Эрдсийн нөөц, баялгийг дэд бүтэц, эдийн засаг, хүрээлэн буй байгаль орчин, улс төр, нийгмийн хүчин зүйлс, хууль эрх зүйн орчны өнөөгийн байдал, ирээдүйн төлөвлөгөө, төрөөс баримтлах

бодлогод нийцүүлэн, эрэх, хайх, олборлох, боловсруулах замаар эдийн засгийн үр ашигтай геологи, уул уурхайн үйлдвэрлэлийг дэмжих нь уул уурхайн салбарын хөгжлийн үндэс болно. Үүнтэй уялдуулж стратегийн (15 орд¹) болон боломжит стратегийн (39 орд) ач холбогдол бүхий нийт 54 ордыг олборлох, ашиглах, боловсруулах өнөөгийн болон хэтийн байдлыг матрицын шинжилгээний аргаар дотоод (уул уурхайн үзүүлэлтүүд), гадаад (дэд бүтэц, эдийн засаг, байгаль орчин, нийгэм улс төр, хууль эрх зүйн орчны үзүүлэлтүүд) хүчин зүйлсийг үнэлж тэргүүлэх ач холбогдлыг тогтоосон болно. Стратегийн ач холбогдол бүхий 15 ордоос нүүрсний 4 орд, зэсийн 3 орд, ураны 3 орд, алтны 1 орд, мөнгөний 1 орд, төмрийн хүдрийн 1 орд, цайр, хар тугалганы 1 орд, фосфоритын 1 орд байна.

Судалгааны арга

Матрицын шинжилгээний аргаар тухайн бизнесийн гол давуу талуудыг үнэлэхдээ дотоод хүчин зүйлс, гадаад хүчин зүйлсийн үнэлгээг хийдэг. Дотоод хүчин зүйлсийн үнэлгээний матрицын арга нь тухайн бизнесийн үйл ажиллагааны гол давуу ба сул талыг үнэлэх эсвэл аудит хийх стратегийн менежментийн нэг арга хэрэгсэл юм. Түүнчлэн дотоод хүчин зүйлсийн хоорондын уялдаа холбоог тогтооход дотоод хүчин зүйлсийн матрицын үнэлгээ чухал ач холбогдолтой. Гадаад хүчин зүйлсийн үнэлгээний матрицын арга нь тухайн бизнесийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх стратегийн менежментийн арга хэрэгсэл болно. Гадаад хүчин зүйлсийн матрицын үнэлгээ нь тухайн бизнест тулгамдаж буй асуудлууд, давуу нөхцөл байдал, боломжуудыг бодитоор үнэлж, эрэмбэлэх сайн арга болно. Дотоод хүчин зүйлсийн үнэлгээний матриц, гадаад хүчин зүйлсийн үнэлгээний матриц нь зарчмын хувьд төстэй бөгөөд гол ялгаа нь загварт оруулж байгаа хүчин зүйлсийн төрөл болно.

Стратегийн болон боломжит стратегийн ордуудыг матрицын шинжилгээний аргаар үнэлэхдээ дотоод хүчин зүйлсийн үнэлгээг тухайн ордын уул уурхайн үзүүлэлтээр, гадаад хүчин зүйлсийн үнэлгээг дэд бүтэц, эдийн засаг, байгаль орчин, нийгэм улс төр, хууль эрх зүйн орчны үзүүлэлтээр хийсэн болно. Гадаад, дотоод хүчин

зүйлсийн матрицын шинжилгээг дараах үе шаттайгаар хийв. Үүнд:

1. Үндсэн хүчин зүйлсийн үзүүлэлтүүдийг тодорхойлох.

2. Үндсэн үзүүлэлтийг тодорхойлон үзүүлэлт тус бүрийн хувьд үнэлгээг хийх. Ач холбогдолын түвшин нь 0-4 гэсэн утгыг авч байгаа бөгөөд хамгийн өндөр үнэлгээ нь "4", сайн "3", дунд "2", муу "1", ач хобогдолгүй эсвэл байхгүй "0" гэсэн үнэлгээг авна.

3. Үндсэн хүчин зүйлсийн үзүүлэлтийг ач холбогдолын түвшингээр нь эрэмбэлж жинг тодорхойлсон. Ач холбогдлын түвшингээр үнэлэхэд жингийн нийт дүн нь 100 хувь буюу 1-тэй тэнцэнэ.

4. Жигнэсэн үнэлгээг тооцон нийлбэрийг бодож, тухайн ордын матрицын үнэлгээг гаргана. Жигнэсэн үнэлгээгээр хамгийн өндөр утга авсан орд нь тухайн хүчин зүйлсийн хувьд хамгийн давуу талтай бөгөөд бага утга авсан орд нь тухайн хүчин зүйлсийн хувьд сул, дутагдалтай байгааг илтгэнэ.

5. Жигнэсэн үнэлгээний үндсэн дээр тэргүүлэх ач холбогдлын түвшинг (1) уул уурхайн үзүүлэлтийн матриц, (2) уул уурхай, дэд бүтцийн үзүүлэлтүүдийн матриц, (3) уул уурхай, эдийн засгийн үзүүлэлтүүдийн матриц, (4) уул уурхай, байгаль орчин, нийгэм улс төрийн үзүүлэлтүүдийн матриц, (5) уул уурхай, хууль эрх зүйн орчны үзүүлэлтүүдийн матрицаар тус тус илэрхийлж, нийт 54 ордын хувьд эдгээр бүх хүчин зүйлсээр онц, сайн, дунд үнэлгээ авсан ордуудыг тэргүүлэх ач холбогдлоор нь дүгнэн гаргалаа.

Эрдсийн нооц, баялгийг төрөөс баримтлах бодлогод нийцүүлэн, эрэх, хайх, олборлох, боловсруулах замаар эдийн засгийн үр ашигтай геологи, уул уурхайн үйлдвэрлэлийг дэмжих нь уул уурхайн салбарын хөгжлийн үндэс болно. Иймд Монгол Улсын томоохон буюу стратегийн болон боломжит стратегийн ордуудыг матрицын шинжилгээний аргаар дотоод, гадаад хүчин зүйлсийг үнэлэн ач холбогдлын түвшингээр нь дүгнэж эрэмбэллээ.

Уул уурхайн үзүүлэлтийн үнэлгээ нь дотоодын хүчин зүйлсийн үнэлгээ болно. Энэ нь тухайн ордыг ашиглахад уул уурхайн талаас нь авч үзэхэд өнөөгийн нөхцөл байдал нь ямар түвшинд байгааг илтгэнэ. Уул уурхайн үзүүлэлтийг 6 бүлгийн нийт 18 асуултаар дүгнэв. Үнэлгээ өндөр байх тусам ач холбогдолын түвшин өндөр байгааг илтгэнэ.

Уул уурхайн үзүүлэлтээр үнэлгээний үр дүнг харвал, одоогоор стратегийн ордод тооцогдож байгаа 15 ордоос онц үнэлгээг Эрдэнэт, Шивээ овоо, Тавантолгой ордууд хамгийн өндөр үнэлгээ буюу 1.78 оноогоор авсан бол сайн үнэлгээг Оюутолгой (1.66), Бороо (1.66), Нарийн сухайт

¹ Судалгааны боловсруулалт хийх үед алтны Гацуурт орд нь стратегийн ач холбогдолтой ордын жагсаалтанд ороогүй, боломжит стратегийн ордын жагсаалтанд орсон байсан болно.

(1.63), Цагаан суварга (1.61), Багануур (1.59); дунд үнэлгээг Гурванбулаг (1.54), Бүрэнхаан (1.49), Дорнот (1.44), Төмөртэйн овоо (1.37) харин муу үнэлгээг Асгат (1.32), Мардай (1.32), Төмөртэй (1.29) ордууд тус тус авчээ.

Дээрх ордуудын үнэлгээнд нөлөөлсөн үзүүлэлтүүдийг нөлөөллөөр нь эрэмбэлэн авч үзвэл стратегийн гэж нэрлэгдэж буй 15 ордын уул уурхайн үзүүлэлт нь тэдгээрийн лицензийн талбайн хэмжээ болон нөөцийн өсөн нэмэгдэх чадвар, ашиглалтын лицензийн эзэмшлийн асуудлууд болон байгаль орчны нөхөн сэргээлтийн байдал зэргээс шууд хамаарч байгааг ажиглаж болно. нь ашигт малтмалын төрөл нь байгаа нь тэдгээрийн

Уул уурхайн хүчин зүйлс нь зэс, давс, нүүрсний зах зээлийн гадаад дотоод борлуулалт өргөн хүрээ, үнийн тогтвортой байдал, ашиглалт, олборлолтын нөхцөл зэрэг харьцангуй бусдаас давамгайлж нөхцөлдүүдээс голлон шалтгаалж байна. Ордын ашиглалт, олборлолтын ажилд нөлөөлөх бас нэг чухал хүчин зүйлс нь дэвшилтэт арга аргачлал болон орчин үеийн техник хэрэгслийг геологийн хайгуул, олборлолтын ажилд нэвтрүүлэх, нарийн мэргэжлийн боловсон хүчин, өндөр зэрэглэлийн лаборатори зэрэг болно.

Дэд бүтцийн үзүүлэлтийн үнэлгээ нь гадаад хүчин зүйлсийн үнэлгээний нэг чухал хэсэг болно. Энэ нь тухайн ордыг ашиглахад уул уурхайн, дэд бүтцийн талаас нь авч үзэхэд өнөөгийн нөхцөл байдал нь ямар түвшинд байгааг илтгэн харуулна. Дэд бүтцийн үзүүлэлтийг 2 бүлгийн нийт 16 асуултаар дүгнэн харуулав. Үнэлгээ өндөр байх тусам ач холбогдлын түвшин өндөр байгааг илтгэнэ.

Матрицын шинжилгээний үнэлгээний үр дүнгээр, стратегийн 15 ордоос, уул уурхайн ба дэд бүтцийн үзүүлэлтээрээ онц үнэлгээг Эрдэнэт, дэд бүтэц онц боловч уул уурхайн үзүүлэлт нь сайн үнэлгээг Нарийнсухайт, уул уурхайн үзүүлэлт нь онц боловч дэд бүтцийн үзүүлэлт нь дунд үнэлгээг Шивээ овоо, Тавантолгой ордууд тус тус авч байна.

Зэс, нүүрсний ордуудын дэд бүтэц харьцангуй шийдэгдсэн, ирээдүйтэй болох нь харагдаж байна. Мөн ордуудын ашигт малтмалын тархалтын зүй тогтол нь дэд бүтэцийн үзүүлэлтүүдэд нөлөөтэй /төмөр, хар тугалга, цайр/ ажиглаж болно.

Эдийн засгийн үзүүлэлтийн үнэлгээ нь гадаад хүчин зүйлсийн үнэлгээний бас нэг чухал хэсэг болно. Уул уурхайг хөгжүүлэхэд эдийн засгийн таатай байдал чухал. Геологи, уул уурхайн төслүүд нь урт хугацаанд үргэлжилж, тухайн төсөлд гаргасан зардлаа багагүй хугацааны дараа нөхдөг тул улс төрийн тогтвортой байдал болоод дэлхийн эдийн засгийн таатай нөлөөллийг сайтар

тооцож үзэх шаардлага гардаг. Иймээс тухайн ордыг эдийн засгийн үр ашигтай олборлоход өнөөгийн нөхцөл байдал болон ирээдүйн дэлхийн эдийн засгийн чиг хандлага хэрхэн нөлөөлхийг матрицын шинжилгээний аргаар харууллаа. Эдийн засгийн үзүүлэлтийг 1 бүлгийн нийт 8 асуултаар дүгнэв.

Үнэлгээний үр дүнгээс харвал одоогоор стратегийн ордод тооцогдож байгаа 15 ордоос, үзүүлэлтээрээ уул уурхай ба эдийн засаг нь хосолсон онц үнэлгээг Эрдэнэт, Тавантолгойн ордууд, эдийн засаг онц боловч уул уурхайн үзүүлэлт нь сайн үнэлгээг Бороо, Оюутолгойн ордууд авсан бол уул уурхайн үзүүлэлт нь онц боловч эдийн засгийн үзүүлэлт нь Шивээ овоо ордын хувьд дунд байна.

Стратегийн 15 ордууд нь эдийн засгийн хувьд харьцангуй тогтвортой мэт боловч борлуулах зах зээл явцуу, нэмүү өртөг шингэсэн завсрын болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж хязгаарлагдмал байдал ажиглагдаж байна. Иймээс дэлхийн зах зээлд эрэлт өсч, үнэ тогтвортой бөгөөд өсөх хандлагатай байгаа ашигт малтмалын орд газрыг дэвшилтэт технологиор олборлон, улмаар нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг бий болгох нь зүйтэй болно.

Байгаль орчин, нийгэм улс төрийн үзүүлэлтийн үнэлгээ нь гадаад хүчин зүйлсийн үнэлгээний нэг хэсэг болно. Бизнесийн орчин болоод орон нутгийн иргэдийн оролцоо, харилцан хамтын ажиллагаа, талуудын ашиг сонирхолд нийцүүлээгүй төслийг, цаашид тогтвортой, үр дүнтэй болгон хэрэгжүүлэхэд хүндрэл учирдаг.

Үнэлгээний дүнгээс харвал, үзүүлэлтээрээ уул уурхай ба байгаль орчин, нийгэм улс төр нь хосолсон онц үнэлгээг Эрдэнэт, Шивээ овоо, Тавантолгойн ордууд, байгаль орчин, нийгэм улс төр онц боловч уул уурхайн үзүүлэлт нь сайн үнэлгээг Багануур, Бороо, Нарийн сухайт, Цагаан суварга, Оюутолгойн ордууд авсан дүн гарч байна. Стратегийн 15 ордууд нь байгаль орчин, нийгэм улс төрийн нөлөөллийн хувьд харьцангуй тогтвортой байна. Учир нь дийлэнх ордууд нь ашиглалт явуулаад тодорхой хугацаа өнгөрч, үйл ажиллагаан нь жигдэрсэн байна. Харин ордуудын үнэлгээнд хамгийн ихээр нөлөөлж байгаа асуудал бол орд болон уурхайг түшиглэсэн суурин газар, шинэ бүтээн байгуулалт, ажлын байр нэмэгдэх эсэх талаарх нийгмийн хүлээлт болж байна.

Хууль, эрх зүйн орчны үзүүлэлтийн үнэлгээ нь гадаад хүчин зүйлсийн үнэлгээний нэг хэсэг болно. Энэ нь тухайн ордыг ашиглахад уул уурхайн, хууль эрх зүйн орчны хүчин зүйлсийн нөлөөлөл өнөөгийн нөхцөл байдалд ямар түвшинд байгааг матрицын шинжилгээний аргаар илтгэн харуулна.

Стратегийн 15 ордоос уул уурхайн ба хууль эрхзүйн орчны матриц шинжилгээний үр дүнгийн үзүүлэлтээрээ уул уурхай ба хууль эрхзүйн орчин нь хосолсон онц үнэлгээг Эрдэнэт, Шивээ овоо, Таван толгойн ордууд, хууль эрхзүйн орчин онц боловч уул уурхайн үзүүлэлт нь сайн үнэлгээг Бороо, Нарийнсүхайд, Цагаан суварга, Багануурын ордууд авсан бол уул уурхайн үзүүлэлт нь онц боловч хууль эрхзүйн орчны үзүүлэлт нь дунд гэж Оюутолгой ордын хувьд гарсан. Мөн зэс, нүүрсний төрлийн ашигт малтмалын ашиглалт, олборлолтын хууль эрхзүйн орчны таатай нөхцөл бүрдсэн байгаа нь харягдсан.

Голлох хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн

Голлох хүчин зүйлсийн шинжилгээгээр тухайн орд бүрийн хувьд уул уурхай, дэд бүтэц, эдийн засаг, байгаль орчин, нийгэм улс төр, хууль, эрх зүйн орчны үзүүлэлтүүдээс эерэгээр болон сөргөөр нөлөөлсөн үзүүлэлтүүдийг дүгнэсэн. Жишээ болгож Асгатын мөнгөний ордыг авч үзэхэд уг мөнгөний орд нь стратегийн ач холбогдол бүхий орд боловч ордыг ашиглахад ОХУ, Монгол Улс хоёр улсын хамтын эзэмшил, ордыг ашиглахад уул уурхайн технологи хүндрэлтэй, тухайн ордыг ашиглах хатуу хучилттай замтай боловч улсын чанартай авто зам, төмөр замаас хол алслагдсан, тусгай хамгаалалтын бүсэд оршдог зэрэг нь тус ордын үнэлгээнд нөлөөлсөн байна.

Нийт 54 ордуудыг ашигт малтмалын төрлөөр нь харьцуулан үзэхэд зэс, давс, коксжих нүүрс, хүрэн нүүрс, чулуун нүүрс, төмрийн орд газрыг олборлох, үйлдвэрлэлийг хөгжүүлэх уул уурхайн үзүүлэлтийн дундаж өндөр байна. Дэд бүтцийн үзүүлэлтийн дундажыг авч үзэхэд зэс, хар тугалга, цайр, уран, чулуун нүүрсийн ордуудын хувьд өндөр байна. Зэс, кокс нүүрс, чулуун нүүрс, алт, газрын ховор элемент, давс, хүрэн нүүрсний ордуудын эдийн засгийн үзүүлэлтийн дундаж нь өндөр байна. Байгаль орчин, нийгэм, улс төрийн үзүүлэлтийн хувьд зэс, кокс нүүрс, хар тугалга, цайрын ордуудын дундаж нь өндөр байна. Хар тугалга, цайр, зэс, кокс хүүрс, төмөр, ураны ордуудын хууль, эрх зүйн орчны үзүүлэлтийн дундаж нь өндөр байна.

Мөн металл биш ашигт малтмалын ордууд, зэс хар, тугалга цайраас бусад металл ашигт малтмалыг олборлох, ашиглахад уул уурхай, дэд

бүтэц, эдийн засаг, байгаль орчин, нийгэм улс төр, хууль эрх зүйн орчин сайн бүрдээгүй байна. Түүнчлэн эрчим хүчний ашигт малтмалын хувьд ураны уул уурхайн, байгаль орчин, нийгэм улс төрийн орчин бүрдээгүй байна гэж үзэж болно. Хүрэн нүүрсний ордууд нь бусад нүүрсстэй харьцуулахад дэд бүтэц, хууль эрх зүй, эдийн засгийн орчин хангалттай бус байна.

Шинжилгээний дүнгээр, стратегийн ба боломжит стратегийн ач холбогдол бүхий нийт 54 ордуудын тэргүүлэх ач холбогдолыг тогтоосон болно. Тухайн ордыг ашиглах өнөөгийн болон хэтийн төлөвийг уул уурхайн талаас нь 18 асуултаар, дэд бүтцийн талаас нь 16 асуултаар үнэлсэн.

Уул уурхайн болон дэд бүтцийн үзүүлэлтийн үнэлгээний үр дүнг онц, сайн, дунд, муу гэсэн дөрвөн бүлэгт хувааж эрэмбэлэж матрицын шинжилгээний үр дүнг Хүснэгт 1-д, уул уурхай, дэд бүтцийн үнэлгээний үр дүнд хамгийн ихээр нөлөөлсөн үзүүлэлтийг Хүснэгт 2-т тус тус харуулав.

Дээрхи хүснэгтүүдээс харахад одоогоор стратегийн гэж нэрлэгдэж байгаа 15 ордыг дотор нь дэд бүтцийн үзүүлэлтээр нь чадамжтай ба чадамжгүй гэж ангилаж болохоор байна. Жишээлбэл: Эрдэнэт, Оюутолгой, Шивээ овоо, Нарийнсүхайд, Багануур, Тавантолгой, Бороо, Цагаан суварга, Гурванбулаг, Дорнод, Төмөртэй овоо ордуудыг дэд бүтцийн хувьд чадамжтай, бусад ордуудыг чадамжгүй орд гэж үнэлж болохоор байна.

Түүнчлэн уул уурхай, дэд бүтцийн хүчин зүйлсийн матрицын шинжилгээний үр дүнг ашигт малтмалын төрлөөр нь харахад (Хүснэгт 3) зэс, нүүрсний ордуудын дэд бүтэц харьцангуй шийдэгдсэн бөгөөд ирээдүйтэй болох нь мөн ордуудын ашигт малтмалын тархалтын зүй тогтол нь дэд бүтцийн үзүүлэлтэнд нөлөөлөлтэй /төмөр, хар тугалга, цайр/ байна.

Энэ мэтчилэн бусад гадаад хүчин зүйлсийг, уул уурхайтай уялдуулан судалсан судалгааны үр дүн болон Монгол Улсын Уул уурхайн яамнаас тооцоолсон уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэтийн төлөвлөлтийн тооцооны үндсэн дээр Монгол Улсын томоохон ордуудыг олборлох, ашиглах, боловсруулах хэтийн төлвийн бүсчилэлийг өөрөөр хэлбэл уул уурхайн салбарыг хөгжүүлэх бүсчилэлийг тодорхойлсон. (Зур 1)

Хүснэгт 1.

Уул уурхай, дэд бүтцийн үзүүлэлтийн матрицын шинжилгээний үр дүн

		Уул уурхай			
		Онц	Сайн	Дунд	Муу
Онц	Эрдэнэт (1.60 1.78)	Нарийн сухайт (1.50 1.63) Барилгт (1.45 1.59) Багануур (1.63 1.59) Төмөргөлгой (1.53 1.56)	Улаан овоо (1.45 1.41)	Налайх (1.38 1.32)	
	Адуунчулуу (1.30 1.78)	Оюутолгой (1.23 1.66) Чандган тал (1.33 1.63) Алаг тогоо (1.23 1.61) Пайдам нуур (1.25 1.61)	Гурванбулаг (1.30 1.54) Цагаан даваа (1.23 1.49) Дорног (1.30 1.44) Төмөргүйн овоо (1.23 1.37)	Мардай (1.28 1.32)	
	Шивээ овоо (1.20 1.78) Таван толгой (1.20 1.78)	Бороо (1.00 1.66) Цагаан суварга (1.20 1.61) Нүүрст хөтгөр (1.03 1.61) Хөөтийн хонгор (1.03 1.59) Талбулаг (1.15 1.59)	Төгрөг нуур (1.15 1.54) Өвдөг худаг (чулуун нүүрс) (1.18 1.51) Өвдөг худаг (хүрэн нүүрс) (1.15 1.51) Хөөт (1.13 1.49) Цав (1.00 1.46) Баянтээг (1.08 1.44)	Могойн гол (1.13 1.32) Төмөргүй (1.20 1.29) Сайхан овоо (1.00 1.27) Наран толгой (1.10 1.24) Жанчивлангийн бүлэг орд (1.05 1.05) Баяндаваа (1.05 1.05)	
Дунд		Тэвшийн говь (0.93 1.63) Мөнгөн өндөр (0.85 1.63) Шүдэн уул (0.85 1.61)	Шаврын царам (0.88 1.49) Улаан (0.90 1.49) Бүрххаан (0.88 1.49) Зээгт (0.95 1.44) Цагаан цав (0.93 1.44) Онгилог нуур (0.73 1.41) Манхан уул (0.85 1.41)	Ширээ уул (0.75 1.34) Хар гарвагатай (0.78 1.34) Асгат (0.85 1.32) Тавт (0.75 1.29) Лугийн гол (0.98 1.27) Хонгор (0.80 1.22) Хөх адар (0.75 0.95) Улаан уул (0.70 0.93)	
Муу					

Хүснэгт 2.

Уул уурхайн, дэд бүтцийн хүчин зүйлсийн матрицын шинжилгээний үнэлгээнд хамгийн ихээр нөлөөлж буй үзүүлэлтүүд /ихээс бага руу эрэмбэлсэн байдлаар, нөлөөлсөн ордын тоо/

	Эрэмбэ	Хамгийн ихээр нөлөөлж буй үзүүлэлтүүд (дугаар)	Ордын тоо
Уул уурхайн үнэлгээ	I	Лицензийн талбайн хэмжээ том жижиг (3)	7
		Нөөц өсөх боломжтой эсэх (9)	6
	II	Байгалийн нөхөн сэргээх үйл ажиллагаа хүндрэлтэй эсэх (18)	5
		Ашиглалтын лицензийн эзэмших эрх (1)	4
	III	Ашиглалт явуулж байгаа болон явуулах гэж буй аж ахуйн нэгж лиценз эзэмшдэг эсэх (2)	2
		Нөөцөөр хир дээгүүр ордог /олон улсын жишгээр/ (8)	2
Гадаадын ямар нэг нөөцийн кодын ангилал бий эсэх (12)		2	
Дэд бүтцийн үнэлгээ	I	Улаанбаатар хотоос орд хүрэх зай (23)	14
		Эрчим хүчний хэдэн эх үүсвэртэй (35)	14
		Харьяалагдах аймгийн төвөөс орд хүрэх зай (24)	14
		Ордоос хамгийн ойрхон хилийн боомт хүрэх зай (26)	14
		Ордоос үйлдвэр, технологийн парк хүрэх зай	14
		Орд төмөр замын шугамтай холбогдсон эсэх (28)	13
		Ордоос улсын чанартай автозам хүртэлх зай (29)	12
		Эрчим хүчтэй холбогдсон эсэх (34)	12
	II	Гадаргын доорхи усны нөөцийн хэмжээ (32)	10
		Геоморфологийн байршил (20)	9
		Уур амьсгал (21)	7
	III	Ордын байрлаж буй сум хөрш оронтой хиллэдэг эсэх (25)	7
		Олборлох үйл ажиллагаа явуулахад байгаль, уур амьсгалын хүндрэлтэй эсэх (22)	4
		Орд хатуу хучилттай эсвэл уурхайн замтай холбогдсон эсэх (30)	2

Хүснэгт 3.

Уул уурхай, дэд бүтцийн хүчин зүйлсийн матрицын шинжилгээний үр дүн ашигт малтмалын төрлөөр

		Уул уурхай		
		сайн	дунд	муу
Дэд бүтэц	сайн	зэс кокс нүүрс хүрэн нүүрс чулуун нүүрс	уран төмөр	хар тугалга, цайр
	дунд	давс	алт мөнгө цайр, хар тугалга цеолиг пироп	газрын ховор элемент цагаан тугалга, гянгболд
	муу		фосфорит	зэс, цайр гөлтгөнө хайлуур жонш



Зур.1. Уул уурхайн салбарыг хөгжүүлэх бүсчилсэн төлөвлөгөө

Уул уурхайн салбарыг хөгжүүлэх бүсчилсэн төлөвлөгөөнөөс харахад Эрдэнэт, Төмөртэй, Овоот ордыг түшиглэсэн Эрдэнэт-Дарханы бүс, Багануурын ордыг түшиглэсэн Багануурын бүс, Шивээ-Овоо, Цагаан суварга ордыг түшиглэсэн Говьсүмбэр-Чойрын бүс, Таван толгой, Оюутолгой, Нарийн сухайт ордыг түшиглэсэн Өмнөговийн бүс, Адуунчулуун ордыг түшиглэсэн

Чойбалсан бүсийг тэргүүлэх шатанд хөгжүүлэх нь зүйтэй юм.

Дүгнэлт

Манай улс байгалийн баялгийн их нөөцтэй боловч эрдэс баялгийн салбараасаа хэт хамааралтай байх нь эрсдлийг дагуулна. Учир нь

ашигт малтмалын баялаг нь шавхагдаж дуусдаг, нөхөн сэргээгдэхгүй баялаг юм. Иймээс эрдэс баялагийн бүтээгдэхүүний зохистой олборлолтын хэмжээг тогтоож, экспортод гаргаж байгаа эрдэс баялгийн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлийн үнэ ханшаар худалдаалах, түүнчлэн зарим эрдэс баялгийн бүтээгдэхүүнийг олон улсын стандартад нийцсэн, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн хэлбэрээр зах зээлд гаргах нь зүйтэй юм.

Үүнтэй уялдуулж Монгол Улсын Ашигт Малтмалын тухай хуульд заасан стратегийн болон боломжит стратегийн ач холбогдол бүхий нийт 54 ордыг олборлох, ашиглах, боловсруулах өнөөгийн болон хэгийн төлөв байдлыг матрицын шинжилгээний аргаар үнэлж, тэргүүлэх ач холбогдолыг судалж тогтоосон болно. Матрицын шинжилгээний үнэлгээг хийхдээ уул уурхайн талаас 18 асуултаар, дэд бүтцийн талаас нь 16 асуултаар дүгнэж, уул уурхай, дэд бүтцийн

үзүүлэлтийн үнэлгээний үр дүнтэй уялдуулан тодорхойлов. Матрицын шинжилгээний үр дүнд тулгуурлан уул уурхайн салбарыг хөгжүүлэх бүсчилэлийг тогтоов.

Ашигласан хэвлэл

Ашигт малтмалын тухай хууль, 2006 он

Газрын хэвлийн тухай хууль,

“Монголын геологи ба ашигт малтмал”, Ү боть, Улаанбаатар хот 2012 он, Ж.Бямба нар

“Монголын геологи ба ашигт малтмал”, Ү1 боть, Улаанбаатар хот 2012 он, Ж.Бямба нар

“Монголын геологи ба ашигт малтмал”, ҮII боть, Улаанбаатар хот 2012 он, Ж.Бямба нар

Хуулийн цахим мэдээллийн сан - <http://www.legalinfo.mn>

Үндэсний статистикийн хорооны мэдээллийн сан - <http://www.1212.mn>

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого - <http://www.legalinfo.mn/law/details/9756>